

НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/049/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Платиниум прогресс аудит ХХК-ийн захирал: Ж.Баяртуул Утас: 99066015, Цахим хаяг: Auditbalance6015@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.13 № 631
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
П.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант оны нийт орлогыг 13,946.3 сая төгрөг, нийт зардлыг 13,011.9 сая төгрөг, 934.4 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 9,845.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 9,950.4 сая төгрөгийн зардал гарган, 104.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тус төвд Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газраас 423.0 сая төгрөгийн машин, техник хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 95.0 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стнадартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/төгрөгөөр/

№	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,626,909,917.44	1,524,473,771.91
1.1.2	Дансны авлага	10,350,488.31	4,194,000.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	129,972,867.08	74,811,981.68
1.1.6	Бараа материал	619,054,586.92	641,424,767.92
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	19,000,000.00	14,598,497.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,405,287,859.75	2,259,503,018.51
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,635,791,584.94	3,900,902,387.87
1.2.2	Биет бус хөрөнгө	129,777.92	180,527.98
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,635,921,362.86	3,901,082,915.85
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,041,209,222.61	6,160,585,934.36
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	4,084,316.00	552,125,968.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,084,316.00	815,802,027.40
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,139,967,000.00	815,802,027.40
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,139,967,000.00	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,144,051,316.00	1,367,927,995.40
2.3	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.3.1.	Өмч: - төрийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.2.	- хувийн		
2.3.5.	Нэмж төлөгдсөн капитал	1,000,000.00	1,000,000.00
2.3.6.	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8.	Эздийн өмчийн бусад хэсэг	1,628,853,000.00	1,628,853,000.00
2.3.9.	Хуримтлагдсан ашиг	3,267,304,906.61	3,162,804,938.96
2.3.10.			
2.3.11.	Эзэмшигчдийн өмчийн дүн	4,897,157,906.61	4,792,657,938.96
2.4	ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	6,041,209,222.61	6,160,585,934.36

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	9,291,864,139.36	9,281,328,122.26
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	9,291,864,139.36	9,281,328,122.26
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	5,647,771.94	12,943,580.40
6	Бусад орлого	248,887,240.68	551,608,854.00
7	Ерөнхий ба удирдлагын зардал	8,586,386,397.94	9,895,219,638.91
8	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	960,012,754.04	(49,339,082.25)
9	Орлогын татварын зардал	95,436,498.21	55,160,885.40
10	Татварын дараах ашиг (алдагдал)	864,576,255.83	(104,499,967.65)
11	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	864,576,255.83	(104,499,967.65)
12	Орлогын нийт дүн	864,576,255.83	(104,499,967.65)
13	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,000,000.00	-	2,389,425,154.76	2,390,425,154.76
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			13,303,496.02	13,303,496.02
3	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	1,628,853,000.00	2,402,728,650.78	4,032,581,650.78
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			864,576,255.83	864,576,255.83
5	2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,000,000.00	1,628,853,000.00	3,267,304,906.61	4,897,157,906.61
6	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(104,499,967.65)	(104,499,967.65)
7	2025 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,000,000.00	1,628,853,000.00	3,162,804,938.96	4,792,657,938.96

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	9,297,511,911.30	9,292,366,702.66
	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	1,436,781,436.30	1,047,939,001.54

“Хан-Уул дүүргийн тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ

	Татаас санхүүжилтийн орлого	7,860,730,475.00	8,244,427,701.12
	Бусад мөнгөн орлого	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн	8,050,168,269.39	9,370,119,548.19
	Ажиллагчдад төлсөн	3,278,829,236.15	4,175,987,363.20
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	953,334,696.02	1,207,661,483.14
	Бараа материал худалдан авахад төлсөн	41,980,300.00	45,439,200.00
	Ашиглалтын зардалд төлсөн	183,596,774.50	323,554,737.38
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	673,714,324.30	632,454,905.60
	Татварын байгууллагад төлсөн	557,975,332.29	409,302,396.00
	Даатгалын төлбөрт төлсөн	22,163,520.00	4,244,188.50
	Бусад мөнгөн зарлага	2,338,574,086.13	2,571,475,274.37
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,247,343,641.91	(77,752,845.53)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн	85,875,400.00	24,683,300.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	85,875,400.00	24,683,300.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(85,875,400.00)	(24,683,300.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү		
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,161,468,241.91	(102,436,145.53)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	465,441,675.53	1,626,909,917.44
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,626,909,917.44	1,524,473,771.91

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны биелэлт		2025 оны биелэлт		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	6,289,020.74	7,860,730.48	11,791,095.71	8,244,427.70	3,546,668.01	70%

“Хан-Уул дүүргийн тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ

	Борлуулалтын орлого	2,835,080.60	1,436,781.44	2,155,172.15	1,049,844.00	1,105,328.15	49%
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	1,388,854.24		551,608.85	(551,608.85)	
	Нийт орлого	9,124,101.33	10,686,366.15	13,946,267.87	9,845,880.56	4,100,387.31	71%
2	ББӨ	-	-		-		
	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,550,661.78	4,041,779.75	6,062,669.63	5,142,287.83	920,381.80	85%
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	511,190.70	521,217.70	781,826.54	657,754.90	124,071.65	84%
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,880.81	182,096.77	273,145.16	342,254.74	(69,109.58)	125%
	Бичиг хэргийн зардал	4,548.79	6,980.49	10,470.74	5,765.32	4,705.42	55%
	Тээвэр, шатахууны зардал	594,452.35	464,814.55	697,221.83	433,489.51	263,732.32	62%
	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,764.18	15,726.59	23,589.89	22,658.59	931.30	96%
	Ном, хэвлэлийн зардал	-	10,835.00	16,252.50	-	16,252.50	0%
	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,051,164.38	916,371.30	1,374,556.95	439,559.30	934,997.65	32%
	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,059.52	22,404.12	33,606.18	24,761.85	8,844.33	74%
	Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд	170,349.28	184,532.37	276,798.56	212,720.80	64,077.76	77%
	Нормын хувцас, зөөлөн эдлэл	141,091.40	154,180.80	231,271.20	143,707.20	87,564.00	62%
	Багаж, техник, хэрэгсэл	2,088.19	17,464.91	26,197.37	54,541.59	(28,344.22)	208%
	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	55,483.64	107,381.92	161,072.88	97,371.09	63,701.79	60%
	Тохижилт /урсгал засвар/	1,169,111.17	563,847.73	845,771.59	943,145.30	(97,373.71)	112%
	Томилолт, зочны зардал	10,159.79	11,535.40	17,303.10	4,212.12	13,090.98	24%
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	195,773.64	370,000.63	555,000.94	291,861.97	263,138.97	53%
	Даатгалын үйлчилгээ	15,280.31	22,163.52	33,245.28	3,630.64	29,614.64	11%
	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	643.50	1,022.57	1,533.85	10,875.43	(9,341.58)	709%
	Газрын төлбөр	1,351.56	4,197.89	6,296.84	-	6,296.84	0%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,100.00	7,000.00	10,500.00	7,000.00	3,500.00	67%	
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,342.45	777.98	1,166.97	1,596.70	(429.73)	137%	
Хүүний төлбөрт төлсөн -ТӨҮГ	-	-	-	-	-		
Татварын байгууллагад төлсөн	8,507.71	3,163.85	4,745.78	-	4,745.78	0%	
Бусад мөнгөн зарлага	25,576.41	11,464.05	17,196.07	26,151.06	(8,954.99)	152%	

	Бараа үйлчилгээний бусад зардал	250,994.15	370,558.64	555,837.96	556,349.93	(511.97)	100%
	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	406,560.96	551,067.86	826,601.80	407,941.77	418,660.02	49%
	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,340.00	42,800.00	64,200.00	65,582.00	(1,382.00)	102%
	Нийт зардал	8,380,476.66	8,605,386.40	12,908,079.60	9,895,219.64	3,012,859.96	77%
3	Татварын өмнөх ашиг /алдагдал/	743,624.67	2,080,979.75	1,038,188.27	(49,339.08)	1,087,527.35	-5%
4	Татварын зардал	74,362.47	208,097.98	103,818.83	55,160.89	48,657.94	53%
5	Татварын дараах ашиг (алдагдал)	669,262.20	1,872,881.78	934,369.44	(104,499.97)	1,038,869.41	-11%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,490,757.4 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн тодруулга тайланд ерөнхий ба удирдлагын зардлыг 3,490,757.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, MNS-6817-4:2020 стандартын санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг; 5.2.1.7.2-т “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” заалт, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 43,490.6 мянган төгрөгийн 5 зөрчил¹ илэрснээс, 12,150.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 135,840.6 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар илрүүлсэн 43,490.6 мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

Өмнөх оны аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэх үндэслэлээр хариуцлага тооцуулах албан шаардлага авсан захирал, нягтлан бодогч нарт 12,150.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон урамшууллыг буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Албан шаардлага

Тайлант онд зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой зөв төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-д "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, алдагдалтай ажилласан зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт-1:Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 25,000.0 мянган төгрөгийг нийгмийн баталгаа хангахад, 565.7 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд зарцуулсан байна. Энэ нь МУЕС-ын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.1-д "Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулж төсвийг хуваарилан зарцуулахдаа үр ашиггүй, тэвчиж болох зардлыг танах, хэмнэлтийн горимыг чанд мөрдөн ажиллах талаар харьяа байгууллагын удирдлагад үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцож ажиллах", 1.4.2-д "байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох", 1.4.3-д "тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлс худалдан авахгүй байх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, хөтөлбөр, арга хэмжээний зардлуудыг хэмнэх, төсвийн хэмнэлтийг горимыг хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

2. Авлагатай холбоотой асуудал.

Илрүүлэлт-3: Авлагын дансны үлдэгдэлд олон жил болсон, төлөгдөх боломжгүй, эзэн холбогдогч, оршин суух хаяг тодорхойгүй 3,234.0 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:Насжилт өндөртэй авлагыг барагдуулах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3. Өглөгтэй холбоотой асуудал.

Илрүүлэлт-4: Өглөгийн дансны үлдэгдэлд олон жил болсон, төлөгдөх боломжгүй, эзэн холбогдогч, оршин суух хаяг тодорхойгүй 2,541.0 мянган төгрөгийн өглөг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.6 дахь “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Насжилт өндөртэй өглөгийг барагдуулах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн тодруулга тайланд ерөнхий ба удирдлагын зардлыг дутуу тайлагнасан.	1	3,490,757.4			1	3,490,757.4	1	3,490,757.4				
Дүн	1	3,490,757.4			1	3,490,757.4	1	3,490,757.4				

/мянган
төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх оны аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэх үндэслэлээр хариуцлага тооцуулах албан шаардлага авсан захирал, нягтлан бодогч нарт урамшуулал олгосон.	1	12,150.0	1	12,150.0								
Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 25000.0 мянган төгрөгийг нийгмийн баталгаа хангахад, 565.7 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд зарцуулсан.	1	25,565.7					1	25,565.7				
Зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой зөв төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, 104,499.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан.	1	0.0			1	0.0						
Авлагын дансны үлдэгдэлд олон жил болсон, төлөгдөх боломжгүй, эзэн холбогдогч, оршин суух хаяг тодорхойгүй 3,234.0 мянган төгрөгийн авлагатай байна.	1	3,234.0					1	3,234.0				
Өглөгийн дансны үлдэгдэлд олон жил болсон, төлөгдөх боломжгүй, эзэн холбогдогч, оршин суух хаяг тодорхойгүй 2,541.0 мянган төгрөгийн өглөгтэй байна.	1	2,541.0					1	2,541.0				
Дүн	5	43,490.6	1	12,150.0	1	0.0	3	31,340.6				